



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 8/420

Улаанбаатар хот

Г Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 1.21 дэх хэсэг, Засгийн газрын (2016-2020) үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.2 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 289 дүгээр тогтооолоор батлагдсан "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах журмыг нэгдүгээр, эрсдэл тодорхойлох удирдамжийг хоёрдугаар, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх товлолын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Эрт илрүүлэг үзлэгийг энэхүү журам, эрсдэл тодорхойлох удирдамж, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх товлолын дагуу хийж гүйцэтгэхийг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
- Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга наарт үүрэг болгосугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Эмнэлгийн тусlamжийн газар (М.Баттүвшин), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.
- Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Журам батлах тухай" 2016 оны 12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081729

Эрүүл мэндийн сайдын 2018 оны
10 дүгээр сарын 18 өдрийн дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд
суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт
хамруулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлст өртөх, өвчин эмгэг хожуу оношлогдох, хүндрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад хийгдэх эрт илрүүлэг үзлэг (цаашид “илрүүлэг үзлэг” гэх)-тэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Илрүүлэг үзлэгийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон эрүүл мэндийн даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллага хийнэ.
- 1.3 Илрүүлэг үзлэг хийхдээ энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан эрсдэл тодорхойлох удирдамжийг хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан хийх эрт илрүүлгийн хугацаа, давтамж, түүний ач холбогдол, үр дүн, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгоход ашиглана.
- 1.4 Энэхүү журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх товлолын жагсаалт, холбогдох журмын дагуу эрүүл мэндийн байгууллагууд илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих зорилтот бүлгийг тодруулж, төлөвлөгөө гарган зохион байгуулна.
- 1.5 Илрүүлэг үзлэгтэй холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг холбогдох дүрэм, журам, удирдамж, зааврын дагуу цаг хугацаанд нь шуурхай, үнэн зөв мэдээлнэ.
- 1.6 Илрүүлэг үзлэгийг зохион байгуулж байгаатай холбогдуулан хамрагдсан үйлчлүүлэгч бүрийг эмчийн үзлэгийн бүртгэлд “ӨОУА-10”-ын дагуу Z код-оор бүртгэнэ.

Хоёр. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үүрэг

- 2.1 Харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амын судалгааг өмнөх жилийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор гарган, илрүүлэг үзлэг шинжилгээ хийх товлолын дагуу бүрэн хамруулна.
- 2.2 Илрүүлэг үзлэг хийх эмч нарт сургалт зохион байгуулж, холбогдох эмнэлзүйн стандарт, заавар, удирдамжаар хангана.
- 2.3 Илрүүлэг үзлэгт хамрагдагсдын судалгаанд үндэслэн тухайн оны эхний улиралд багтаан шаардлагатай эм, урвалж, тоног төхөөрөмжийн жагсаалт, бүртгэлийн маягт зэргийн бэлтгэлийг хангана.

- 2.4 Илрүүлэг үзлэгээр өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийг тухайн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд оношлон эмчлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд лавлагас шатлалын эрүүл мэндийн байгууллагад холбогдох журмын дагуу илгээнэ.
- 2.5 Илгээхдээ 13А маягтын баруун дээд өнцөгт “ЭРТ ИЛРҮҮЛЭГ” гэсэн тэмдэг тавьж өгнө. Харин илрүүлэг үзлэгээр эрүүл гарсан тохиолдолд илрүүлэг үзлэгийн дараагийн товлол болон эрүүл амьдралын хэв маягийн талаар зөвлөгөө өгнө.
- 2.6 Хүн амьг илрүүлэг үзлэгт хамруулсны дараа зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчний эрсдлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх зөвлөмж, зааврыг иргэний эрүүл мэндийн дэвтэрт нарийвчлан бичиж, зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллана.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- 3.1 Эрт илрүүлэг үзлэгийг холбогдох эмнэлзүйн стандарт, заавар, удирдамж, товлол, журмын дагуу хийх бөгөөд үйлчлүүлэгчийг чирэгдүүлэхгүй байх орчин бурдүүлнэ.
- 3.2 Илрүүлэг үзлэгээр өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийн өвчлөл, түүний эмчилгээ, хяналтын талаарх мэдээллийг тухайн эрүүл мэндийн байгууллага өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эргэн мэдээлнэ.
- 3.3. Үйлчлүүлэгчид эрсдлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх зөвлөмж, зааврыг иргэний эрүүл мэндийн дэвтэрт нарийвчлан бичиж, зөвлөгөө өгнө.
- 3.4 Илрүүлэг үзлэгийн тайланг сар бүр холбогдох эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

Дөрөв. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн үүрэг

- 4.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс илгээсэн илрүүлэг үзлэгээр эерэг гарсан, анхан шатлалд тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй үйлчлүүлэгчийг хүлээн авч, холбогдох эмнэлзүйн стандарт, заавар, удирдамжийн дагуу оношлох, эмчлэх, шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлэх, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эргэн мэдээлнэ.
- 4.2 Иргэдийг илрүүлэг үзлэгт хамруулах хуваарийг сараар гаргаж, эмч нарын ачааллыг зохицуулж ажиллана.
- 4.3 Илрүүлэг үзлэг хийхэд шаардлагатай эм, урвалж, тоног төхөөрөмжийн жагсаалт, бүртгэлийн маяг зэргийн бэлтгэлийг тухайн оны эхний улиралд багтаан хангана.
- 4.4 Хавдар бүртгэгчээс хавдрын илрүүлэг үзлэгт хамрагдаж онош тодорсон болон эсийн өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийн мэдээллийг баталгаажуулан холбогдох удирдамж, тушаалын дагуу мэдээлнэ.
- 4.5 Илрүүлэг үзлэгээр илэрсэн өвчлөл тус бүрийн мэдээлэл, үр дүнг тухайн мэргэжлийн кабинетын их эмч өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эргэн мэдээлнэ.
- 4.6 Үйлчлүүлэгчид өвчлөлийн эрсдлийг бууруулах, амьдралын буруу хэв маягийг өөрчлөх зөвлөмж, зааврыг иргэний эрүүл мэндийн дэвтэрт нарийвчлан бичиж, зөвлөгөө өгнө.

- 4.7 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нарт илрүүлгээр илэрсэн үйлчлүүлэгчийн өвчлөл, түүний эмчилгээ, хяналтын талаар зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалт зохион байгуулна.
- 4.8 Сүрьеэ өвчин болон бэлгийн замаар дамжих халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгийг холбогдох стандарт, заавар, журмын дагуу зохион байгуулна.
- 4.9 Илрүүлэг үзлэгийн тайланг сар бүр эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

Тав. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үүрэг

- 5.1 Илрүүлэг үзлэгийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, илрүүлэг үзлэгийн явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.
- 5.2 Илрүүлэг үзлэгийн тайланг хүлээн авч нэгтгэн жилийн эцэст нэгдсэн тайланг гарган, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.
- 5.3 Илрүүлэг үзлэг шаардлагатай тоног, төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, бүртгэлийн маягт, хүний нөөцөд судалгаа хийж, жил бүрийн төсөвт суулгана.
- 5.4 Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн илрүүлэг үзлэгийн эргэн мэдээллийг 7 хоногоор авч, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд мэдээлнэ.
- 5.5 Илрүүлэг үзлэгийн мэдээллийн санг үүсгэн, нэгтгэж, хяналт үнэлгээ хийж, хариу арга хэмжээ авах болон анхаарах асуудлаар зөвлөгөө өгч ажиллана.

Зургаа. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн үүрэг

- 6.1 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгээс илгээсэн сэжигтэй тохиолдлыг нарийвчилсан оношилгоо, шинжилгээнд оруулж, оношийг баталгаажуулан, эмчилгээ хийж, цаашид тавих хяналт, баримтлах дэглэм, заавар зөвлөгөөг өгч, иргэний эрүүл мэндийн дэвтэрт бичиж тэмдэглэнэ. Мөн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт үйлчлүүлэгчийн талаар эргэн мэдээлнэ.
- 6.2 Хүн амын дунд эрүүл мэндийн болон илрүүлгийн үзлэгийн талаарх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.
- 6.3 Мэргэжлийн эмч нарын багийг орон нутагт ажиллуулж, илрүүлэг үзлэгийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.

--0-0-0--

Хүн, амьг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрг илрүүлэг үзлэгт хамруулах

насны ангилал, шалгаан, эрүүл мэндийн эрсдэл тодорхойлох удирдамж

№	Үзлэг	Үзлэгт хамрагдах үндэслэл	
		Насны ангилал, эрүүл мэндийн эрсдэл	Эрг илрүүлсэний ач холбогдол
1	<p>Зүрх судасны өвчиний эрсдлийн үнэлгээ</p> <p>Монгол улсын эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр зүрх судасны тогтолцооны өвчин(ЗСТӨ) 10000 хүн амд 1113.7 буюу өвчлөлийн тэргүүлэх 3 дах шалтгаан, нас баралт 10000 хүн амд 503,9 буюу нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна. 2017 оны байдааар Зүрх судасны тогтолцооны өвчиний улмаас жил бүр 5000-5500 хүн буюу 3 хүний нэг нь нас барж байна. Зүрх-судасны тогтолцооны өвчиний шалтгаант нас баралтын түвшинг насны бүлгийн хүйсээр харьцуулбал 45-64 насны бүлгийн эрэгтэйчүүдийн дунд 10000 хүн амд ногдох зурхийн титэм өвчин 25.8, тархины харвалт 19.8, цусны даралт ихсэлт 1.3 ногдох байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшинтэй харьцуулбал зурхний ишемийн нас баралт 4.7 дахин, тархинд цус харвалтын өвчиний шалтгаант нас баралт 2.0 дахин өндөр, цусны даралт ихсэх өвчиний шалтгаант нас баралт 1.4 дахин их байна.</p>	<p>18-34 насанд жилд 1 удаа, 40 наснаас эхлэн жил бүр 1 удаа</p> <p>ЗСТӨ-ний нийт эрсдэл гэдэг нь ойрын 10 жилд аминд халтай ба халтугийн ЗСТӨ-өөр өвдөх магадлалыг хэлнэ. Хүний нас, хүйс, цусны даралт, тамхи татдаг эсэх, нийт холестеролын хэмжээ дээр үндэспэн ЗСТӨ-ний нийт эрсдэлийг хүснэгтээр тодорхойлдог. ЗСАӨ-ний эрсдэлт хүчин зүйлсэд хөдөлгөөний хомдол, буруу хоолилт, илүүдэл жин ба таргалалт, артерийн гипертензи, чихрийн шижин, тамхидалт, удамшилын өгүүлэлмж хамаарна. ЗСТӨ-ний эрсдэл өндөртэй хүмүүсийг илрүүлж, тэднийг амьдралын эрүүл хэв маяг, зан үйлд сургаснаар өвчлөлөөс сэргийлэх буран боломжтой. Илрүүлэг үзлэгээр нэгээнт өвчилсөн нь тогтоогдсон тохиолдолд цусны даралт бууруулах, өөх тоосны илүүдэл хэмжээг багасгах, цус шингэрүүлэх эмчилгээг эрг эхлүүлж, хүндрэлзэс сэргийлэх боломж олгоно.</p>	<p>ЗСТӨ дөртөх эрсдлийг эрг илрүүлснээр ЗСӨ-ний хүндрэл, нас баралтыг бууруула.</p> <p>Үнд:</p> <p>-Зүрхний шигдээс -Тархины харвалт</p>

Эрүүл мэндийн сайдны
2018 оны № дугээр сарын 1
дүгээр тушаалын
2 дугаар хавсралт

Цусны даралт ихсэх эмгэгийн эрт илрүүлэг үзлэг

2013 оны ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тодорхойлох судалгаагаар Артерийн даралт ихсэлт (АДИ)-ийн тархалт нийт хүн амын дунд 27.5% байв. Эрэгтэйчүүдийн дундах АДИ-ийн тархалт (30.5%) эмэгтэйчүүдээс (24.5%) илүү байв. 2017 оны ЭМ-ийн үзүүлэлтээр 2017 эрүүл мэндийн үзүүлэлтэд Цусны даралт ихсэх өвчин нь хүн амын дунд тохиолдож буй зуух-судасны тогтолцооны өвчлөлийн 49.2 хувийг эзэлж, 10 000 хүн амд 564.3 байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд 10 000 хүн амд 727.6, эрэгтэйчүүд 10 000 хүн амд 394.7 тохиолдож байна. Байршилаар нь үзэхэд Хангайн болон төвийн бусийн хүн амд илүүтэй энэ өвчлөлөөр өвдөж байна. Хангайн болон Төвийн бусийн аймгууд дотроос Архангай/1049.9/, Булган/926.5/, Баянхонгор/845.1/, Төв/797.5/, Өмнөговь/706.2/ аймгуудад өндөр байна.

18-34 насанд жилд 1 удаа, (цэрэгт явах, сургуульд элсэх, ажилд орох, эмэгтэйчүүдийн үзлэг, жирэмсний хяналтанд орох, жолооны дамжаанд суралцах зэрэг) 40 нааснаас эхэлж жилд 1 удаа хийнэ. Гурав болон түнээс дээш удаагийн хэмжилтээр систолын даралт 130 мөнгөн усны багана (МУБ) буюу түүнээс дээш хэмжээнд байхыг arterийн гипертензи гэнэ. Артерийн гипертензи нь опон эрхтэнийг гэмтээж, эмнэл зүйн олон шинж тэмдгээр илэрдэг. Цусны даралтыг бууруулахад титэм судасны өвчлөлийг 49% -иар, тархины харвалтыг 62% -иар бууруулдаг байна. Илрүүлэг үзлэгээр цусны даралт ихсэлтийг эрт илрүүлэх нь тархины судасны өвчлөл болон нас барагалтыг тог бууруулна. 2.1 Цусны даралт ихсэх эмгэгийн эрт илрүүлгийг 18-аас дээш насны хүмүүст, мөн хувь хүний хүсэлтийн дагуу хийнэ. 2.2 Цусны даралтыг хэмжих эрт илрүүлгийн үзлэгийг багадаа 2 жилд нэг удаа 21-ээс дээш насныханд, столийн даралт 130 мм муб –ээс, диастолын даралт 80 мм муб – аас их хүн амд хийнэ.

Эрт илрүүлэг үзлэгээр АДИ-ийг илрүүлэх нь тархины харвалт, зурхний шигдээс, гэнэтийн нас баралтыг бууруулах ач холбогдолтой.

Цусны даралт үзэх

х халдварт бус өвчин, эрүүл мэндийн эрсдлийн үзлэг

Биеийн жингийн индекс, биеийн жингийн индекс, төвийн таргалалт

Халдварт бус өвчиний (ХБӨ) эрсдэлт хучин зүйлсийн тархалтын түвшинг тогтох судалгаагаар Артерийн даралт ихсэлт нийт хүн амын дунд 27.5% байв. Эрэгтэйчүүдийн дундах артерийн даралт ихсэлт (АДИ)-ийн тархалт (30.5%) эмэгтэйчүүдээс (24.5%) илүү байв.

Бүх насынханд, жилд нэг удаа ХБӨ, нас баралтын шалтгаан болсон эрсдэлт хучин зүйлсийн тархалтын судалгаагаар 15-64 наасны хүн амын дунд 2 хүний нэг нь илүүдэл жин, таргалалтай, 3 хүний нэг нь цусны даралт ихсэлттэй, 4 хүн тутмын нэг нь хөдөлгөөний хомсдолтой, 2 эрэгтэйн нэг нь тамхи татдаг, 3 хүний нэг нь архи хэрэглэдэг, үүнээс 10 хүний 1 нь архийт хэтрүүлэн хэрэглэж байна. Биеийн жингийн илүүдэл ба таргалалт, хөдөлгөөний хомсдол нь чихрийн шижин-2-т нөлөөлөх гол эрсдэлт хучин зүйлс юм. Мөн хүн амын 61.9 хувь нь цусан дахь холостеролын хэмжээ ихэссэн буюу ихсэх эрсдэлтэй, 8.3 хувь нь цусан дахь сахарын бөөрчлөлт (далд хэлбэр)-тэй байна. Түүнчлэн 3 болон түүнээс олон өвчиний эрсдэлтэй хүн амын эзлэх хувь 10.5 хувиар намагдэж, өвчиний ямар нэг эрсдэлт хучин зүйлс огт илрээгүй хүн ам дөнгөж 1 хувьтай байна. Хэвийн жингтэй харьцуулахад таргалалтай хүмүүст чихрийн шижин-2 хэвшинжээр өвдөх эрсдэл 10-20 дахин их байдаг. Амьдралын хэв маяг (хөдөлгөөний хомсдолтой эсэх, даралт бууруулах эм хэрэглэж буй эсэх, жирэмсэн эсэх, таргалалт ба биеийн жингийн илүүдэлтэй эсэх, хоолилгын байдал, бусад эмийн болон архи, тамхины хэрэглээ) удамшилын өвчиний тодорхойлох асуумж.

Амьдралын хэв маягаас үүдэлтэй эрүүл мэндийн эрсдлийг тодорхойлно.
Биеийн жингийн индекс (БЖИ)
- Төвийн таргалалт
- Бодисын солилцооны алдагдал

1. Зонхилон тохиолдо

<p>2017 оны эруул мэндийн үзүүлэлтэд чихрийн шижин өвчин нь дотоод шүүрэл, тэжээлийн бодисын солилцооны өвчлөлийн 44.1 хувийг эзэлж, 10 000 хүн амд 100.8 байгаа нь өнгөрсөн он /2016 онд 78.6/-оос 22.2-оор өссөн байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 10 000 хүн амд 94.6, эмэгтэйчүүд 10 000 хүн амд 106.8 байна. Насны булгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр 19 581 буюу 10 000 хүн амд 354.2 тохиолдож байна. Чихрийн шижин өвчиний эрт илрүүлгийн үзлэг нийт 485 315 эрэгтэйчүүд 10 000 хүн амд 94.6, эмэгтэйчүүд 10 000 хүн амд 106.8 байна. Насны булгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр 19 581 буюу 10 000 хүн амд 354.2 тохиолдож байна.</p> <p>Чихрийн шижин гүйцэтгэлийн эрт илрүүлэлтэд чихрийн шижин өвчиний эрт илрүүлгийн үзлэг нийт 485 315 эрэгтэйчүүд 10 000 хүн амд 94.6, эмэгтэйчүүд 10 000 хүн амд 106.8 байна. Насны булгээр нь авч үзэхэд 45-65 насныханд хамгийн өндөр 19 581 буюу 10 000 хүн амд 354.2 тохиолдож байна.</p>	<p>35 наснаас эхэлж жилд 1 удаа наслын булгээр нь авч үзэхэд 35-65 насныханд хамгийн өндөр 19 581 буюу 10 000 хүн амд 354.2 тохиолдож байна. Чихрийн шижин өвчиний эрт илрүүлгийн үзлэг нийт 485 315 хүн хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 63.2 хувийг эзэлж байна. Үр дүнгийн үзүүлэлтээр Эруул мэндийн хөгжлийн төв Эруул мэндийн үзүүлэлт, 2017 79 хэвийн 97.1%, өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй 2.9% илэрч хоёрдогч шатлалын эмнэлэгт онош баттуулахаар илгээсэн байна.</p> <p>Чихрийн шижин хэв шинж 2 эрг илрүүлгийн үзлэг хамрагдлын хувийг хүйсээр авч үзэхэд үзлэгт хамрагдвал зохих нийт эрэгтэй хүн амын 42.0 хувь, эмэгтэй хүн амын 58.0 хувь нь эрг илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. Чихрийн шижин эрг илрүүлгийн үзлэгээс онош баттуулахаар хоёрдогч шатлалын эмнэлэгт 22 188 хүн ирснээс 1 279 хүн буюу нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 0.3 хувь нь чихрийн шижин хэв шинж 2 өвчиний тохиолдол батлагдсан байна.</p>
	<p>Далд хэлбэрийн чихрийн шижинг оношпох, чихрийн шижингийн үеийн гол хүндрэл болох нуд сохрох, беер, зурх, нуд, хөлний үхжил хүндрэлээс сэргийнэ. Чихрийн шижин нь судасны хатуурлыг даамжуулдаг</p>

6	Цусны өөх тосны хэмжээ ихэссэн эсвэл холестрол бууруулах эм хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь 61.9 байна.	Цусанд холестерол илрүүлэх		
40	Монгол улсын эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр 10000 хүн амд 1007,6 буюу өвчлөлийн таргуулэх 3 дахь шалтгаан болж байна. Нас баралт 10000 хүн амд 503,9 буюу нас баралтын таргуулэх шалтгаан болж байна. Жил бур 5000-5500 хүн буюу 3 хүний 1 нь зурх судасны өвчинээс болж нас барж байна.	наснаас эхлэн жил 1 удаа, 40 наснаас эхлэн жил бур 1 удаа судасны тогтолцооны өвчиний шалтгаант нас баралтын түвшинг насны бүлэг, хүйсээр харьцуулбал 45-64 насны буулгийн эрэгтэйчүүдийн дунд 10000 хүн амд ногдох зурхний ишеми өвчин 25,8, тархины харвалт 19,8, цусны даралт ихсэлт 1,3 ногдож байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшингтэй харьцуулбал зурхний ишеми өвчиний нас баралт 4,7 дахин, тархины харвалтын шалтгаант нас баралт 2,0 дахин өндөр, цусны даралт ихсэлтээс нас баралт 1,4 дахин их байна.	наснаас эхлэн жил 1 удаа, 40 наснаас эхлэн жил бур 1 удаа судасны тогтолцооны өвчиний шалтгаант нас баралтын түвшинг насны бүлэг, хүйсээр харьцуулбал 45-64 насны буулгийн эрэгтэйчүүдийн дунд 10000 хүн амд ногдох зурхний ишеми өвчин 25,8, тархины харвалт 19,8, цусны даралт ихсэлт 1,3 ногдож байгаа бөгөөд тухайн насны эмэгтэйчүүдийн нас баралтын түвшингтэй харьцуулбал зурхний ишеми өвчиний нас баралт 4,7 дахин, тархины харвалтын шалтгаант нас баралт 2,0 дахин өндөр, цусны даралт ихсэлтээс нас баралт 1,4 дахин их байна.	Артерийн судасны хатуурал, титэм судасны нарийслыг эрт илрүүлснээр цусны даралт ихсэлт, ЗШ, тархины харвалт, тэдээрийн хүндэрэл, нас баралтаас урьдчилан сэргийлэх боломжтой. Цусанд холестерол боломжтой. - Цусанд холестерол сэргийлэх боломжтой.
3	Зүрхний цахилгаан бичлэг	ЦДИ-ээс зурх томрох, зурхийн хэм ба дамжуулалтын алдагдал, зурхийн шигдээс, титэм судасны ишемийг эрт илрүүлж, ЗШ тархины харвалт, ЗАД-аас урьдчилсан сэргийлнэ. - Зурхийн шигдээс -Зурхий хэм, дамжуулалтын алдагдал -Зурхий тэжээлийн дутагдал -Зурхий томрол		

Й илрүүлэг үзлэг

Сүрьеэ өвчний илрүүлэг үзлэг

2017 оны эрүүл мэндийн үзүүлэлтэд шинээр илэрсэн сурьеэгийн тохиолдлыг насны ангиллаар нь авч үзвэл 15-24 нас, 25-34 насанд өндөр байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүд 55.1 хувь, эмэгтэйчүд 44.9 хувийг тус тус эзэлж байна.

18-34 насынханд жилд 1 удаа Сүрьеэгийн эмчилгээний хугацаа урт, өргөг зардал өндөртэй, оношлогдох хүртлээ мөн эмчилгээний явцад өвчтөнд өндөр хэмжээний зардлыг гаргаж байгаа нь гэр булийн орлогыг бууруулахад шууд нөлөөлдөг. Монгол улсад сурьеэгийн оношилгоо, эмчилгээний үед хувь хүн, өрхөөс гарах зардлыг судлахааны урьдчилсан үр дүнгээс харахад олон эмэнд тэсвэртэй сурьеэ өргтсөн өрхийн 85%, эмэнд мэдрэг сурьеэ өргтсөн өрхийн 65% нь санхүүгийн дарамтанд орсон байна. Олон эмэнд тэсвэртэй сурьеэгийн хувьд нэг өрхөөс гаргасан дундаж зардал нь 1328 ам. доллар байхад эмэнд мэдрэг сурьеэд өргтсөн өрхийн хувьд 500 ам. доллар байсан. Жилд дунджаар 800 гаруй хүн сурьеэ өвчиний улмаас хөдөлмөрийн чадвар алдаж, груупт орж, хөдөлмөрийн чадвар тур алдартын тэтгэмжид улсаас нэг тэрбум гаруй төгрөгийг зарцуулж байна. Сурьеэгээ өвчтөний 50 гаруй хувь нь ажилгүй, 70 хувь нь амьжирааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд байна. Цээжний рентгенээр идэвхтэй сурьеэгээ өвчиний шинжилгээ хийх удаан хугацаагаар хамиалгах (> 3 допоо хоногтой) өвчтөнүүдэд СХР-ийг хийхэд өртийн хувьд үр ашигтай байдаг.

Сүрьеэ өвчиний илрүүлэх, уушмын бус сурьеэ өвчин үүсэх, бусдад халдвар дамжухаас сэргийлж, эрт илрүүлсэн тохиолдолд эмчлэгдэх бүрэн боломжтой.

- Уушмын хатгалгаа
- Уушмын хавдар
- Уушмын булага
- Уушмын усжилт
- Ушиг хийжих эмгэг
- Цээжний хөндийн бусад эмзэгүүд

Халдварт өвчний

Бэлгийн замаар дамжих халдварт өвчний илрүүлэг үзлэг

Улсын хэмжээнд БЗДХ сүүлийн 5 жилд туштай буурахгүй, нийт халдварт өвчний тогтол 28-40 гаруй хувийг эзэлж байна. Нийт БЗДХ-ын өвчтөлийн 29,8 хувийг заг хүйтэн, 45 хувийг тэмбүү, 25 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна.

2018 онд тэмбүүгийн 6587 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 65,5 хувийг эмэгтэйчүүд, 34,5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Манай улсад ХДХВ-ын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдэж, өнөөдрийн байдлаар 264 тохиолдоос 42 хүн нас барсан байна. Нийт тохиолдолын 61 хувийг 25-39 наасны хүмүүс эзэлж байна. Нийт 83.3% нь ХДХВ-ын халдварын үедээ, 16.7 хувь нь ДОХ-ын шатандaa байна. Тэмбүүгийн эрт илрүүлгийн үзлэгийг хийхдээ: халдварын өндөр эрсдэлтэй биеэ үнэлэгчид, бэлгийн олон хавтагчтай, мансууруулах бодис хэрэгтэгчид зэрэг өндөр эрсдэлтэй хүн амд серологийн буюу ТРНА сорилыг ашиглан илрүүлдэг.

18-34 насынханд жилд 1 удаа БЗДХ-ийн өвчтөл 15-34 насын хүн амын дунд харьцаангуй өндөр бүртгэгдэж байна. Тэмбүүгийн өвчтөл эрсдэлт бүртгийн хүн ам, нөхөн уржихийн насын нийт хүн ам, жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг хүн амын бүх булэгт өссөн. Эмэгтэйчүүдийн дунд өндөр хувьтай байгаа нь эмнэлэгт хандах, жирэмсний хяналтын үзлэгт хамрагддагтай холбоотой.

Төрөлхийн тэмбүүгийн тохиолдын түвшин ч мөн нэмэгдсээр байна. 2015 онд төрөлхийн тэмбүүгийн 52, 2016 онд 42, 2017 онд 46, 2018 оны эхний 6 сарын байдлаар төрөлхийн тэмбүүгийн 27 тохиолдол тус тус бүртгэгдсэн.

Умайн хүзүүний хавдар, бага аарцгийн хөндийн эрхтнүүдийн үрэвсэл, умайн гадуурх болон ёсөлтгүй жирэмслэлт, бага жинтэй ураг төрөх, амьгүй төрөх, умайн дайврын үрэвсэл, түрүү булчирхайн томрол, хоёрдогч үргүйдэл, бэлгийн супрап, түрүү булчирхайн хавдар, төрөлхийн тэмбүүгийн хүүхэд төрөлчилан хүндэрэлээс урьдчилан сэргийлнэ. Тэмбүү -ХДХВ -Трихомониаз -Заг хүйтэн -Хламиди

10	<p>Элэгний хорт хавдрын тохиолдлын 95% нь 40-аас дээш насанд бүртгэгдэж, жилд 1742 хүн нас барж байна. Нь хожуу шатанд оношлогдож байна.</p> <p>81.7%</p>	<p>Элэг, нойр булачирхай, цэсний эмгэгчүүдийг эрт илгүүлснээр дараах эмгэгээс сэргийнэ.</p> <p>Элэгний хавдар - Элэгний бэлтгэл - Элэгний өөхжилт - Элэгний уйланхай - Элэгний хатуурал - Цэсний үрэвсэл - Цэс чулгуу - Цэсний ерөнхий сувгийн хавдар - Нойр булачирхай - Нойр үрэвсэл</p> <p>- Нойр булачирхайн хавдар - Беөрний үрэвсэл - Беөрний хавдар - Беөрний үйланхай</p>
	<p>Элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэг /Хэвлийн ЭХО/</p> <p>40 нааснаас эхлэн жил бүр 1 удаа Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 13.4 хувийг элэгний өвчлөл эзэлж байгаа ба 10 000 хүн амд 209.5 байна. Бүртгэгдсэн элэгний өвчнүүдээс хорт хавдрын үндсэн шалтгаан болдог архаг хепатит элэгний өвчлөлийн дотор 43.9 хувь эзэлж байна. 2008 оны байдлаар 10 000 хүн амд элэгний өвчин эрэгтэй хүн амд 134, эмэгтэй хүн амд 152 байсан бол 2017 онд эрэгтэй хүн амд 169, эмэгтэй хүн амд 249 болиж нэмэгдсэн байна. Өөр буллагт ангилагүй архаг гепатитаар 10 000 хүн амд 2008 онд 56.4 байсан бол 2017 онд 91.9 буюу 35.5 - аар өссөн байна. Элэгний фиброз ба циррозоор 10 000 хүн амд 2008 онд 47.7 байсан бол 2017 онд 62.0 буюу 14.3-аар өссөн байна. Элэгний бусад өвчинөөр 10000 хүн амд 2008 онд 27.7 байсан бол 2017 онд 48.5 буюу 20.8-аар өссөн үзүүлэлтэй харагдаж байна.</p>	<p>40 нааснаас эхлэн жил бүр 1 удаа Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн 13.4 хувийг элэгний өвчлөл эзэлж байгаа ба 10 000 хүн амд 209.5 байна. Бүртгэгдсэн элэгний өвчнүүдээс хорт хавдрын үндсэн шалтгаан болдог архаг хепатит элэгний өвчлөлийн дотор 43.9 хувь эзэлж байна. 2008 оны байдлаар 10 000 хүн амд элэгний өвчин эрэгтэй хүн амд 134, эмэгтэй хүн амд 152 байсан бол 2017 онд эрэгтэй хүн амд 169, эмэгтэй хүн амд 249 болиж нэмэгдсэн байна. Өөр буллагт ангилагүй архаг гепатитаар 10 000 хүн амд 2008 онд 56.4 байсан бол 2017 онд 91.9 буюу 35.5 - аар өссөн байна. Элэгний фиброз ба циррозоор 10 000 хүн амд 2008 онд 47.7 байсан бол 2017 онд 62.0 буюу 14.3-аар өссөн байна. Элэгний бусад өвчинөөр 10000 хүн амд 2008 онд 27.7 байсан бол 2017 онд 48.5 буюу 20.8-аар өссөн үзүүлэлтэй харагдаж байна.</p>

ЗДРЫН ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ

Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг /Дуран/	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг /Дуран/
2017 оны эрүүл мэндийн үзүүлэлтэд Ходоодны хорт хавдрын 889 шинэ тохиолдол бүртгэгдснээс 64.7% эрэгтэй, 35.3% эмэгтэйчүүд байна. Ходоодны хорт хавдар 100 000 хүн амд 28.8 тохиолдол байгаа ба эрэгтэйд 37.9, эмэгтэйд 20 тохиолдол байна.	<p>2017 оны эрүүл мэндийн үзүүлэлтэд Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын 241 шинэ тохиолдол бүртгэгдсэний 44.0% эрэгтэй, 56.0% эмэгтэйчүүд байна. 100 000 хүн амд 7.8 тохиолдол байгаа ба эрэгтэйд 7.0, эмэгтэйд 8 тохиолдол байна.</p> <p>50-аас дээш насанд 5 жилд 1 удаа Эрсдэлт хүн ам:</p> <ol style="list-style-type: none"> Гэр бүлд бүдүүн гэдэсний хорт хавдраар өвдөж байсан түүхтэй Гэдэсний ямар нэгэн үрэвсэлт өвчнөөр өвдөж байсан(гэр бүлийн өвчиний түүхэнд өвчилсөн хүн байсан бол 45 наснаас дээш 10 жил 1 удаа бүдүүн гэдэсний дуран хийлгэх) Хэвллийн хэсгээр тuya эмчилгээнд орж байсан. Эрт илрүүлэг үзлэгийн 2 төрлийн аргаар хийж болно. Чүнд: <ol style="list-style-type: none"> Өтгөнд цус илрүүлэх Бүдүүн гэдэсний дуран
40 наснаас эхлэн жил бүр 1 удаа Ходоодны хорт хавдрын тохиолдлын 88% нь 40-оос дээш насанд бүртгэгдэж, жилд 664 хүн нас барж байна. 82.5% нь хожуу шатанд оношлогдож байна.	<p>Улаан хоолой, олон ходоодны эмгэг/улаайт, үрэвсэл, шархлаа, хорт хавдар/, түүний хүндрэлээс бүрэн сэргийлэх боломжтой.</p> <p>Ходоодны хорт хавдар</p>

13

Хорт хав

14	.Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэг	Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг
	<p>2017 оны эрүүл мэндийн үзүүлэлтэд Хөхний хорт хавдрын тохиолдлын 98% нь 30 дээш насанд бүртгэгдэж, жилд 76 хүн нас барж байна. 68% нь хожуу үе шатандаа оношлогдож байна.</p> <p>Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг</p> <p>Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг дараах байдалаар хийнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Хөхийг сар тутам өөрөө үзэж шалгах: 20 нааснаас эхэлж хийж занших нь чухал ба сарын тэмдэг ирсний дараа хөх зөвлөрч эмзэгтэл багатай болсон үед хийх нь тохиромжтой. Хөхний рентген зураг бууруу Маммограмм хийлгэх: <p>2017 оны байдлаар умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн үзлэгт зорилтот настны нийт 84 716 эмэгтэй хамрагдсан нь хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 37.4 хувийг эзэлж байна. Эдгээр хамрагдсан үйлчилгээний 4.7 хувь нь пап зерэг буюу умайн хүзүүний эсийн түвшинд өөрчлөлтэй гарсан байна.</p> <p>Умайн хүзүүний хорт хавдрын тохиолдлын 95% нь 30-аас дээш насанд бүртгэгдэж, жилд 1742 хүн нас барж байна. 50% нь хожуу шатанд оношлогдож байна.</p>	<p>30 нааснаас эхлэн 3 жилийн давтамжтайгаар үзлэгт хамрагдана.</p> <p>Умайн хүзүүний өмөн нь бусад хорт хавдруудын адил урьдчилан сэргийлэх боломжтой ба эрт үе шатандаа төгс эмчлэгддэг. Сүүлийн 50 жилийн хугацаанд эрт илрүүлэлт аргыг ашигласнаар, дэлхий даяар умайн хүзүүний хавдрын шалтгаант нас баралтыг 75 хувиар бууруулжээ.</p> <p>Хөхний хорт хавдараас сэргийлэх боломжтой.</p> <p>-</p>

Бүлчирхайн
Урэвсэл,
Хавдар,
Ангол

ердогч
гүйдлээс
огийлэх бүрэн
помжтой.
рүү булагчирхайн
ձар, томрол

Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд сууринлан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ хийх товтолын жагсаалт

№	Үзүүлэлт	Нас				Үзлэг хийгдэх ЭМБ		
		18-34	35-45	46-64	65-аас дээш			
1	Биеийн ерөнхий үзлэг, эрсдлийн үнэлгээ	жил бүр 1 удаа				ӨСТЭМТ, гэрээт ЭМБ		
2	Цусны даралт ихсэх эмгэгийн илрүүлэг үзлэг	18 насанд 1 удаа	40 наснаас эхлэн жилд 1 удаа		гэрээт ЭМБ ӨСТЭМТ, гэрээт ЭМБ			
3	Зүрх судасны өвчиний (ЗСӨ) эрсдлийн үнэлгээ	18 насанд 1 удаа	40 наснаас эхлэн жилд 1 удаа		ӨСТЭМТ, гэрээт ЭМБ			
4	Чихрийн шижинийн илрүүлэг үзлэг	35 наснаас эхлэн жилд 1 удаа				ӨСТЭМТ, гэрээт ЭМБ ӨСТЭМТ, гэрээт ЭМБ		
5	Биийн жингийн индээкс тодорхойлох үзлэг	40 наснаас эхлэн жилд 1 удаа				ӨСТЭМТ, гэрээт ЭМБ ӨСТЭМТ, гэрээт ЭМБ		
6	Халдварт өвчиний илрүүлэг үзлэг	40 наснаас эхлэн жилд 1 удаа				НЭ, гэрээт байгууллага		
7	Сурьеэз өвчиний илрүүлэг үзлэг	жил бүр 1 удаа	40 наснаас эхлэн жилд 1 удаа		НЭ, гэрээт байгууллага			
8	Бэлгийн замаар дамжих халдварт өвчиний илрүүлэг үзлэг	жил бүр 1 удаа	40 наснаас эхлэн жилд 1 удаа		ӨСТЭМТ, гэрээт ЭМБ			
9	Элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэг	40 наснаас эхлэн жилд 1 удаа				НЭ, гэрээт байгууллага		
10	Будуун, шулгуун гэдэсний хорт хавдрын илрүүлэг үзлэг	50 наснаас эхлэн 5 жилд 1 Удаа		НЭ, гэрээт байгууллага				
11	Ходоодны хорт хавдрын илрүүлэг үзлэг	40 наснаас эхлэн жилд 1 удаа				НЭ, гэрээт байгууллага		
12	Хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэг	30 наснаас эхлэн 3 жилийн давтамжтай				НЭ, гэрээт байгууллага		
13	Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэг	30 наснаас эхлэн 3 жилийн давтамжтай				ӨСТЭМТ, гэрээт ЭМБ		
14	Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	50 наснаас эхлэн жилд 1 Удаа				НЭ, гэрээт байгууллага		
ЭРЭГТЭЙ								
12	Хөхний хорт хавдрын илрүүлэг үзлэг	30 наснаас эхлэн 3 жилийн давтамжтай				НЭ, гэрээт байгууллага		
13	Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэг	30 наснаас эхлэн 3 жилийн давтамжтай				ӨСТЭМТ, гэрээт ЭМБ		
14	Түрүү буулчирхайн хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг	50 наснаас эхлэн жилд 1 Удаа				НЭ, гэрээт байгууллага		